



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/317

## Арвайхээр

## Нэмэлт дархлаажуулалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “а”, Эрүүл мэндийн тухай хуулийн 11дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын “Дархлаажуулалтын 10 хоногийг зохион байгуулах тухай” 2019 оны А/207 дугаар тушаалыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** НЬ:

1. Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг 2019 оны 5 дугаар сарын 15-наас 25-ны өдрүүдэд “Улаанбурхан өвчинд цэг тавья” уриан дор аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтын арав хоногоор 10-18 насны хүүхдийг улаанбурхан, улаануудын эсрэг вакцинаар тархвар судлалын заалтаар дархлаажуулах арга хэмжээг зохион байгуулахыг Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Есөнзүйл сумын сүм дундын эмнэлэг, сүм, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт даалгасугай.

3. Улаанбурхан, улаануудын өвчний эсрэг нэмэлт дархлаажуулалтыг орон нутагт зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, үйл ажиллагааны чиглэлийг хоёрдугаар, ажлын төлөвлөгөөг гуравдугаар, вакцин, дагалдах хэрэгслийн хуваарийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

4. Улаанбурхан, улаанууд өвчнөөс сэргийлэх, дархлаажуулалтын ач холбогдлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах, эцэг, эх, асран хамгаалагчдад тайлбарлан таниулах арга хэмжээг эрчимтэй зохион байгуулахыг Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Есөнзүйл сумын сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт, нэмэлт дархлаажуулалт зохион байгуулахад олон нийтийг татан оролцуулах, шаардагдах хүн хүч, техник хэрэгсэлийг зөв хуваарилан, бензин шатахуун болон бусад зардлыг орон нутгийн төсвөөс зарцуулахыг сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Б.Сайнжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

ГАНБОЛД

011100680

Аймгийн Засаг даргын 2019 оны ...<sup>05</sup>  
дугаар сарын...<sup>17</sup> ны өдрийн <sup>13/7</sup> дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

УЛААНБУРХАН, УЛААНУУД ӨВЧНИЙ ЭСРЭГ НЭМЭЛТ  
ДАРХЛААЖУУЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН  
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Б.Сайнжаргал -Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: С.Дуламсүрэн - Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл  
мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн  
хэлтсийн ахлах мэргэжилтэн

Гишүүд: Д.Шивааннүрдэв -Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн  
газрын дарга

Ж.Пүрэвсүрэн -Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрал, соёл,  
урлагийн газрын дарга

С.Санчир -Өвөрхангай аймаг дахь Политехникийн коллежийн  
захирал

А.Отгонцэцэг -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх  
зүйн хэлтсийн дарга

М.Дэлгэрсайхан -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн  
штабын дарга

М.Ганцэцэг -Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын  
Эмнэлгийн тусlamжийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ц.Энхцэцэг -Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн  
газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн

Сумдын Засаг дарга нар

-оOo-

Аймгийн Засаг даргын 2019 оны 05  
дугаар сарын 13-ны өдрийн 1347 дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт

УЛААНБУРХАН, УЛААНУУД ӨВЧНИЙ ЭСРЭГ ВАКЦИНЫ НЭМЭЛТ  
ДАРХЛААЖУУЛАЛТААР ХИЙГДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс
  - 1.1. Нэмэлт дархлаажуулалтыг удирдан зохион байгуулах
  - 1.2. Салбар хоорондын үйл ажиллагааг зохицуулах
  - 1.3. Дархлаажуулалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, цагийн байдалтай уялдуулан холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулах
2. Эрүүл мэндийн газар
  - 2.1. Дархлаажуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах
  - 2.2. Вакцин, дагалдах хэрэгслэлийг хадгалах хөргөгч, зөөврийн савыг бэлтгэх, тооцоог гарган нэн шаардлагатай тоног төхөөрөмжийг ХӨСҮТ-с авах
  - 2.3. Вакциныг түгээх хуваарь, зураглал, тээврийн хэрэгслийн төрөл, маршрутыг гаргах, хадгалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдлыг хангах
  - 2.4. Вакцин, дагалдах хэрэгслийг хүлээн авч, шуурхай түгээх
  - 2.5. Хүн хүч, тоног төхөөрөмжийн судалгааг гаргах
  - 2.6. Дархлаажуулалтын түр цэг болон явуулын багийг байгуулах, уг багт ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургах
  - 2.7. Дархлаажуулалтын нэгж бүрээр дархлаажуулах бичил төлөвлөгөө, маршрутыг гарган мөрдөх
  - 2.8. Дархлаажуулалтын явцад дэмжлэгт хяналт хийж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах
  - 2.9. Дархлаажуулалтын хамралт, дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн мэдээ тайланг өдөр бүр авч, нэгтгэн мэдээлэх
  - 2.10. Дархлаажуулалтын мэдээлэл, сурталчилгаа, харилцаа холбооны төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх
  - 2.11. Нэмэлт дархлаажуулалтын талаар хэвлэлийн бага хурал зохион байгуулах
  - 2.12. Олон нийтэд зориулсан мэдээлэл, сурталчилгааны материалыг түгээх,
  - 2.13. Олон нийтийн цахим сүлжээнд тандалт хийж, шаардлагатай мэдээллийг түгээх
  - 2.14. Дархлаажуулалтын үйл ажиллагааны бичмэл тайланг 5 дугаар сарын 25-ны дотор ХӨСҮТ-д бичгээр болон цахимаар хүргүүлэх
3. Боловсрол, соёл, урлагийн газар
  - 3.1. Ерөнхий боловсролын сургуулийн 10-18 насын сурагчдын судалгааг сургууль тус бүрээр гарган Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтэст энэ оны 5 дугаар сарын 13-ны дотор бичгээр болон цахимаар хүргүүлэх
  - 3.2. Сурагчдыг дархлаажуулах ажлыг зохион байгуулах нэхцлийг бүрдүүлж, хамтран зохион байгуулах
  - 3.3. 10-18 насын хүүхдүүдийн эцэг, эхчүүдэд нэмэлт вакцин хийх талаар мэдээллийг нэгдсэн байдлаар хүргэх
4. Өвөрхангай аймаг дахь Политехникийн коллеж

- 4.1. Политехникийн коллежийн 18 хүртэлх насын оюутны судалгааг гаргаж, Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтэст 5 дугаар сарын 14-ны дотор бичгээр болон цахимаар хүргүүлэх
  - 4.2. Оюутнуудыг дархлаажуулах ажлыг зохион байгуулах нөхцлийг бүрдүүлж, хамтран зохион байгуулах
  - 4.3. Оюутнуудад нэмэлт вакцинд хамрагдах, вакцины ач холбогдлыг сурталчлан таниулах
5. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс
  - 5.1. Харьяа байгууллагуудын 10-18 насын ял эдэлж байгаа иргэдийн судалгааг анги, нэгтгэл тус бүрээр гарган Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтэст энэ оны 5 дугаар сарын 14-ны дотор бичгээр болон цахимаар хүргүүлэх
  - 5.2. Дархлаажуулалтын түр болон явуулын цэгийг байгуулан, зорилтот бүлгийхнийг улаанбурхан, улаануудын эсрэг вакцинаар дархлаажуулах ажлыг зохион байгуулах
6. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб
  - 6.1. Харьяа байгууллагуудын 18 хүртэлх насын цэргийн судалгааг анги нэгтгэл тус бүрээр гарган Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтэст энэ оны 5 дугаар сарын 14-ны дотор бичгээр болон цахимаар хүргүүлэх
  - 6.2. Дархлаажуулалтын түр болон явуулын цэгийг байгуулан, зорилтот бүлгийхнийг улаанбурхан-улаануудын эсрэг вакцинаар дархлаажуулах
7. Сумдын Засаг даргын Тамгын газар
  - 7.1. Улаанбурхан, улаануудын эсрэг нэмэлт дархлаажуулалт зохион байгуулах Засаг даргын захирамж, ажлын төлөвлөгөө болон дархлаажуулах бичил төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх
  - 7.2. Дархлаажуулалтын явуулын болон түр цэгийг нэмэлтээр байгуулан дархлаажуулах арга хэмжээг зохион байгуулах
  - 7.3. Иргэд, аж ахуйн нэгж, олон нийтийн оролцоог дэмжиж дайчлан оролцуулах
  - 7.4. Дархлаажуулалтын талаар сургалт, сурталчилгааг зохион байгуулах
  - 7.5. Шаардлагатай санхүүжилтийг гаргах

-оОо-

Аймгийн Засаг даргын 2019 оны 05  
дугаар сарын 13-ны өдрийн 13:17 дугаар  
захирамжийн гуравдугаар хавсралт

**НЭМЭЛТ ДАРХЛААЖУУЛАЛТААР ХИЙГДЭХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтрагч байгууллага
<b>Нэг. Зохион байгуулалт, бүртгэл, судалгаа</b>				
1.1	Вакцины хүйтэн хэлхээний бэлэн байдлыг бүх түвшинд ханган, нэмэлт дархлаажуулалтад шаардагдах вакцин, дагалдах хэрэгслийг татан авах, хадгалах, түгээх	5 дугаар сарын 14-ны дотор	Эрүүл мэндийн газар	Сум, өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төв
1.2	Улаанбурхан өвчний эсрэг нэмэлт дархлаажуулалтад хамрагдах 10-18 насны хүүхдийн тоог нарийвчлан гаргах	5 дугаар сарын 14-ны дотор	Сум, өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн газар
1.3	Нэмэлт дархлаажуулалтын явуулын болон дэмжлэгт хяналтын багийн бүрэлдэхүүнийг томилох, дархлаажуулалтын бичил төлөвлөгөөг боловсруулах	5 дугаар сарын 14-ны дотор	Сум, өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн газар
1.4	Нэмэлт дархлаажуулалтын үеэр нэмэлтээр дайчлан ажиллуулах сувилагч нарыг томилуулах	5 дугаар сарын 14-ны дотор	Эрүүл мэндийн газар	Хууль, эрх зүйн хэлтэс, Цэргийн штаб
1.5	Дархлаажуулах насны хугацаат цэргийн албан хаагчид, засан хүмүүжүүлэх газрын хүмүүжигчдийн тоог гаргах, дархлаажуулалтын бичил төлөвлөгөө боловсруулах	5 дугаар сарын 14-ны дотор	ЗХ-ны 256-р анги, Хархорин сумын 423-р хорих анги	Эрүүл мэндийн газар
<b>Хоёр. Сургалт</b>				
2.1	Нэмэлт дархлаажуулалт зохион байгуулах, бичил төлөвлөгөө боловсруулах арга аргачлалд сургагч багш нарыг сургах	5 дугаар сарын 14	НБХ, ЭМГ	ХӨСҮТ
2.2	Сум, өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төвийн эмч, вакцинатор сувилагч нарт сургалт зохион байгуулах	5 дугаар сарын 14-ны дотор	НБХ, БСУГ, ЭМГ	Сум, өрхийн эмнэлэг, ЭМТ
2.3	Цэргийн анги нэгтгэл, хорих ангид нэмэлтээр дайчлагдан ажилласх сувилагч нарт сургалт зохион байгуулах	5 дугаар сарын 14-ны дотор	НБХ, ЭМГ	Хууль, эрх зүйн хэлтэс, Цэргийн штаб
<b>Гурав. Дархлаажуулах үйл ажиллагаа</b>				
3.1	Ерөнхий боловсролын сургууль, Политехникийн коллежд дархлаажуулалтын түр цэг байгуулан дархлаажуулалтыг зохион байгуулах	5 дугаар сарын 15-25-нд	Сум, өрхийн эмнэлэг, ЭМТ	БСУГ, Политехникийн коллеж, ЕБС-иуд
3.2	Шинээр татагдаж ирсэн хугацаат цэргийн албан хаагчдыг дархлаажуулах	5 дугаар сарын 15-25-нд	Цэргийн штаб	ЭМГ
3.3	Хорих ангид ял эдэлж байгаа хүмүүжигч нарыг дархлаажуулах	5 дугаар сарын 15-25-нд	Хууль, эрх зүйн хэлтэс	ЭМГ

3.4	Сургуулиас завсардсан, хөгжлийн бэрхшээлтэй гэртээ байдаг хүүхдийг дархлаажуулах	5 дугаар сарын 15-25-нд	Сум, өрхийн эмнэлэг, ЭМТ	ЭМГ
3.5	Нэмэлт дархлаажуулалтын хамралт, дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн тохиолдлын мэдээг өдөр бүр авах, салбарын болон аймаг, орон нутгийн хэмжээнд мэдээллийн сан бүрдүүлэх	5 дугаар сарын 15-25-нд	ЭМГ	ХӨСҮТ

**Дөрөв. Мэдээлэл сургалт, сурталчилгаа**

4.1	Улаанбурхан, улаануудын эсрэг нэмэлт дархлаажуулалтын нээлтийн арга хэмжээг зохион байгуулах	5 дугаар сарын 15	Сум, өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төв	НБХ, БСҮГ ЭМГ,
4.2	Нэмэлт дархлаажуулалтын талаарх мэдээллийг телевиз, радио, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл олон нийтийн сүлжээгээр сурталчлах	5 дугаар сарын 14-25	ЭМГ	НБХ
4.3	Дархлаажуулалтын ач холбогдлыг сурталчилсан гарын авлагыг иргэдэд түгээх	5 дугаар сарын 14-25	Сумдын ЗДТГ	Сум, өрхийн ЭМТ
4.4	Улаанбурхан, улаанууд өвчний эсрэг нэмэлт дархлаажуулалтын талаарх мэдээллийг олон нийтийн газруудад байршуулж сурталчлах	5 дугаар сарын 14-25	Сумдын ЗДТГ	Сум, өрхийн ЭМТ

**Тав. Дэмжлэгт хяналт, хамралтын түргэвчилсан үнэлгээ**

5.1	Нэмэлт дархлаажуулалтын явцад дэмжлэгт хяналт хийх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд мэргэжил арга зүйгээр хангах баг ажиллуулах	5 дугаар сарын 15-25	ЭМГ	НБХ
5.2	Хамралтын түргэвчилсэн үнэлгээг хийх, үнэлгээний дүнд суурилан нөхөн дархлаажуулах	6 дугаар сарын 10-ны дотор	ЭМГ, МХГ	Сум, өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төв
5.3	Нэмэлт дархлаажуулалтын үйл ажиллагааны нэгдсэн тайланг гаргаж, холбогдох газруудад хүргүүлэх	6 дугаар сар	ЭМГ	Сум, өрхийн эмнэлэг, ЭМТ

Аймгийн Засаг даргын 2019 оны ..05..  
дугаар сарын... 13.ны өдрийн 13.7 дугаар  
захирамжийн дөрөвдүгээр хавсралт

**УЛААНБУРХАН, УЛААНУУДЫН ЭСРЭГ ХАВСАРСАН ВАКЦИН,  
ДАГАЛДАХ ХЭРЭГСЛИЙН ХУВААРЬ**

№	Сумдын нэрс	Хамрагдвал зохих хүний тоо	Олгох вакцин /хүн тун/	Өөрөө эвдэрдэг тариур /ширхэг/	Найруул даг тариур /ширхэг/	Аюулгүй хайрцаг /ширхэг/
1	Баруунбаян-Улаан сум	448	490	470	49	4
2	Бат-Өлзий сум	1225	1350	1286	135	11
3	Баянгол сум	635	700	667	70	6
4	Баян-Өндөр сум	561	620	589	62	5
5	Богд сум	918	1010	964	101	8
6	Бүрд сум	450	500	473	50	4
7	Гучин-Ус сум	351	390	369	39	3
8	Есөн зүйл сум	466	520	489	52	4
9	Зүүнбаян-Улаан сум	605	670	635	67	5
10	Нарийнтээл сум	526	580	552	58	5
11	Өлзийт сум	393	440	413	44	3
12	Сант сум	470	520	494	52	4
13	Тарагт сум	300	330	315	33	3
14	Төгрөг сум	423	470	444	47	4
15	Уянга сум	1200	1320	1260	132	11
16	Хайрхандулаан сум	522	580	548	58	5
17	Хархорин сум	1595	1800	1675	180	14
18	Хужирт сум	1150	1270	1208	127	10
19	Арвайхээр сум	5110	5520	5366	552	48
<b>Нийт</b>		<b>17348</b>	<b>19080</b>	<b>18215</b>	<b>1908</b>	<b>155</b>

-оо-